Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Сургалт, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Бадамдорж Баасансүрэн

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 1 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хангах | Тухай бүр | - | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийг жилийн эцээр тайлагнасан байна. | Төрийн албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан/2024.04.03 болон 2024.11.20/. Тус батлуулсан төлөвлөгөөний биелэлтийг хангаж, гүйцэтгэлийг тухай бүр тайлагнан ажиллаж байна. | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Холбогдох тушаал, шийдвэр, албан бичгийн төслийг боловсруулж, баталгаажуулсан байх | Хувиар | - | Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын гарын үсгээр баталгаажих тушаал, шийдвэр, албан бичгийн төслийг тухай бүр боловсруулж, баталгаажуулсан байна. /100 хувь/ | 1. Боловсруулж, баталгаажуулсан тушаалууд:<br>1.1 Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/106 "зайнаас ажиллуулах тухай" тушаалын төслийг боловсруулж, батлуулсан. Тус тушаалын нэгдүгээр хавсралт болох "Албан хаагчийг зайнаас ажиллуулах журам"-ийн төслийг | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулан, бүх газруудаас санал авч, саналыг тусгах эсэх талаарх дүгнэлт бүхий саналын товьёг бэлтгэж, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Тус хэлэлцүүлгээс гарсан шийдвэрийн дагуу журмын хоёрдугаар хавсралт болох “Зайнаас ажиллах боломжтой албан тушаалын жагсаалт, хуваар”-ийг бүх газруудаас дахин санал авч боловсруулан, баталгаажуулсан. Түүнчлэн тус журам болон хуваарь батлагдсантай холбогдуулан албан хаагчийн нэрстэй хуваарийг бэлтгэж Эдийн засаг, хөгжлийн яамны "Teams-General" хэсэгт байршуулж, бүх албан хаагчдад журам, хуваарийг танилцуулж масс и-мэйл хүргүүлсэн ба “Мэдээллийн цаг”-аар журмын танилцуулга болон зайнаас ажилласан тохиолдолд албан хаагчдын цахим системийн бүртгэлийг хэрхэн хийх талаар танилцуулсан. 1.2 Төрийн нарийн бичгийн даргын “Ажлаас чөлөөлөх тухай”/2024.04.16/, “Цалинтай чөлөө олгох тухай”/2024.04.19/ тушаалын төслүүдийг боловсруулж, цаасан хэлбэрээр удирдлагуудад танилцуулж, батлуулсан. 1.3 Төрийн нарийн бичгийн даргын “Орон нутагт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | томилолтоор ажиллуулах тухай” тушаалын төслүүдийг /Говь-Алтай аймаг, Орхон аймгийн Эрдэнэт хот/ боловсруулж, батлуулсан. 1.4 Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Гадаадад томилолтоор ажиллуулах" тухай/Бүгд Найрамдах Солонгос Улс/, "Шагнал олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах" тухай 2024 оны А/10 дугаар тушаалын төслүүдийг боловсруулж, батлуулсан. 1.5 Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Шагнах тухай" 2024 оны А/16, А/19, А/21, А/28, А/29, А/33, А/49 дугаар тушаалын төслүүдийг боловсруулж, батлуулсан. 2. "Гадагшаа чиглэсэн" 41 албан бичиг, "дотогшоо чиглэсэн" 22 дотоод бичигт санал, хариу хүргүүлэх тухай албан бичгийн төслийг боловсруулж, баталгаажуулсан. | | |
| 3 | Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох хүний нөөц болон концессын гэрээний эргэн төлөлттэй холбоотой маргаанд төлөөлөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх | Хувиар | - | Монгол Улсын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох тус яамнаас төлөөлөн оролцож байгаа иргэн болон захиргааны хэрэгт итгэмжлэлээр оролцох, мөн тухай бүр хууль зүйн дэмжлэг, туслалцааг үзүүлсэн | 1. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдсэн "Монгол Улсын Хөгжлийн банк"-ны нэхэмжлэлтэй маргаанд санхүү, төсөв, зээлийн тооцоолол талаас нь дэмжлэг үзүүлж, шүүх хуралдаанд "Эдийн засаг, хөгжлийн яам"-ийг шинжээчийн хамт итгэмжлэн төлөөлж, оролцсон ба болзошгүй өр, | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна /100 хувь/ | төлбөрөөс чөлөөлүүлж шийдвэрлүүлсэн. 2. ТЗУГ-ын хүний нөөцөөр хангах үндсэн чиг үүргийн хүрээнд хамаарах хэрэг болох Иргэн "Д.Энхээ"-г "ажлаас чөлөөлсөн"-д холбогдох маргаанд хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн тухай хуульд холбогдох тайлбарыг өгч, шинжээчийн хамт ажилласан ба Иргэний хэргийн анхан шатны шүүхээс Төрийн нарийн бичгийн даргыг хариуцагчаас хас ч шийдвэрлэсэн. 3. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэгдсэн "Томобюлдинг" ХХК-ны нэхэмжлэлтэй, Хяналтын шатны шүүхэд хянан шийдвэрлэгдсэн "Алтай трест" ХХК-ны нэхэмжлэлтэй хэргүүд болон "Макс рөүд" ХХК-ны нэхэмжлэлтэй иргэний хэргийн Улсын дээд шүүхийн хуралдаанд оролцоход, итгэмжлэгдсэн төлөөлөгчид алдагдал, хохирол, алдангийн тооцоо, зээлийн хүү, ханшийн зөрүүний өөрчлөлт, эдийн засгийн ач холбогдол талаас мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. 4. Нийслэлийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа Иргэн "Болдмандал"-ийг албан тушаалд томилохоос татгалзсан тухай маргааны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт, итгэмжлэгдсэн төлөөлөгч болох нэгжийн даргад дэмжлэг үзүүлэн оролцсон ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн. 5. Нийслэлийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа Иргэн "Өнөрбаяр"-ийг албан тушаалд томилохоос татгалзсан тухай маргааны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт, итгэмжлэгдсэн төлөөлөгч болох нэгжийн даргад дэмжлэг үзүүлэн оролцсон ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн. 6. Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа "Улаан дөл" ХХК-ны нэхэмжлэлтэй маргаанд, Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна. | | |
| 4 | Яамны албан хаагчдыг сургалтад хамруулж, тэтгэлэгт хөтөлбөрүүдэд уламжлах | Хувиар | - | Тухай бүр албан хаагчдыг сургалтад хамруулж, тэтгэлэгт хөтөлбөрт уламжилсан байна. /100 хувь/ | 1. Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага "ЖАЙКА"-ийн урт хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдах албан хаагчдын саналыг бүх газруудаас авч 1 албан хаагчийг тус тэтгэлэгт хөтөлбөрт нэр дэвшүүлэн, тэтгэлгийн материалыг Сангийн яаманд уламжилсан. 2. Шинэ | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зеландын Гадаад хэрэг, худалдааны яамнаас зохион байгуулж буй Төрийн албан хаагчдад зориулсан англи хэлний 61 дэх удаагийн “Худалдааны бодлого” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг нэр дэвшүүлэн,холбогдох материалыг Гадаад харилцааны яаманд уламжилсан. 3. Япон Улсын Засгийн газрын Залуу удирдагч хөтөлбөрийн 2025-2026 оны хичээлийн жилийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах албан хаагчдын саналыг бүх газруудаас авч 1 албан хаагчийг тус тэтгэлэгт хөтөлбөрт нэр дэвшүүлэн, тэтгэлгийн материалыг Япон Улсын Элчин сайдын яаманд уламжилсан. 4. Удирдлагын академийн Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 5 албан хаагчийг мэдээллийг хүргүүлж сургалтад хамруулсан. 5. Удирдлагын академийн "Төрийн захиргааны удирдах албан тушаалтны манлайлал" сэдэвт богино хугацааны танхимын сургалтад 3 удирдах албан тушаалтныг хамруулсан. 6. ЗГХЭГ болон Удирдлагын академиас зохион байгуулсан "Монгол Улсын Хөгжлийн бодлого, үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" танхимын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2 өдрийн сургалтад 4 албан хаагчийг хамруулсан. 7. ЗГХЭГ, БНСУ-ын KDS судалгааны байгууллага, Удирдлагын академи хамтран зохион байгуулсан "Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь" богино хугацааны сургалтад 3 удирдах албан тушаалтныг хамруулсан. 8. ЗГХЭГ, БНСУ-ын KDS судалгааны байгууллага, Удирдлагын академи хамтран зохион байгуулсан "Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага" богино хугацааны сургалтад 3 албан хаагчийг хамруулсан. 9. ЗГХЭГ-аас зохион байгуулсан "Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган"-д 3 албан хаагчийг хамруулсан. 10. Шүүхийн ерөнхий зөвлөлийн "Шүүх шинжилгээний сургалт"-д хамрагдах боломжтой шаардлага хангасан албан хаагчдын мэдээллийг газруудаас авсан. | | |
| 5 | Цаг үеийн шинжтэй шуурхай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Хуулийн хугацаанд шуурхай биелүүлсэн байх /100 хувь/ | 1. Эдийн засаг, хөгжлийн яамны болон түүний харьяа байгууллагуудын шаардлага хангаж буй 37 ажилтан, албан хаагчдыг шагналд тодорхойлуулж, холбогдох материалыг бүрдүүлж, "Төрийн дээд одон медаль"-аар шагнуулахаар ЗГХЭГ, ЕТГ-т хүргүүлсэн. Үүнээс Монгол | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 97, 173 дугаар зарлигаар тус тус 5 албан хаагч Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, 11 албан хаагч Алтан гадас одон, 15 албан хаагч Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан. 2. “Засгийн газрын хүндэт өргөмжлөл”-өөр эдийн засаг, санхүү, худалдааны салбараас шагнуулах нэг албан хаагчийг тодорхойлуулж, журмын дагуу холбогдох баримт, материалуудыг бүрдүүлэн ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд тус албан хаагч Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 95 дугаар захирамжаар шагнагдсан. 3. ЭЗХЯ-ны шаардлага хангаж буй хоёр албан хаагчдыг шагналд тодорхойлуулж, холбогдох материалыг бүрдүүлж, "Салбарын тэргүүн, Хүндэт жуух бичиг"-ээр шагнуулахаар ХЗДХЯ-д хүргүүлсэн бөгөөд тус хоёр албан хаагч нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/221 тоот тушаалаар "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг"-ээр, ХЗДХЯ-ны Хүндэт жуух бичгээр тус тус шагнагдсан. 4. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинжлэх ухаан нэмэгдсэнтэй холбогдуулан Засгийн газрын шагнал "Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" хүндэт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэмдэг, үнэмлэх, хавтас, хавчуурга болон бусад холбогдох материалуудыг, мөн "Шинжлэх ухааны газар"-т харьяалагдах албан хаагчдын "Төрийн дээд одон медаль"-ийг Боловсролын яамнаас хүлээн авч, ажлын хэсгийн уулзалтын хурлын тэмдэглэл хөтөлсөн. 5. ЭЗХЯ болон Монгол Банкны хамтран "Алт худалдах, худалдах авах боломж"-ийн талаар судлах ажлын хэсэгт хууль, эрх зүйн дэлгэрэнгүй судалгаа хийж ажилласан. 6. Төрийн захиргааны албан хаагчийг албан тушаалд томилоход тавигдах шаардлага, сонгон шалгаруулах, томилох үе шат, үндэслэлийн эрх зүйн дэлгэрэнгүй судалгаа хийж удирдлагад хүргүүлсэн. 7. Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийг томилох тухай эрх зүйн дэлгэрэнгүй судалгаа хийж удирдлагад хүргүүлсэн. | | |
| 6 | Санхүүгийн мэдлэг шаардсан ТЭЗҮ, ТЭЗУС боловсруулах гэрээний төслүүдийг хянаж, баталгаажуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | Хувиар | - | Тухай бүр холбогдох гэрээний төслийг боловсруулж, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. /100 хувь/ | 1. Яамны зохион байгуулалтын бусад бүтцийн нэгжүүдээс боловсруулсан дараах гэрээнүүдийг хянаж, нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг тусгаж, боловсруулахад туслалцаа үзүүлэн ажилласан. 1.1. Хэвлэх ажлыг гүйцэтгэх ажил гүйцэтгэх гэрээ; 1.2. Тээврийн хэрэгслийн багц даатгалын гэрээ; 1.3. | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Автомашин ашиглах ЭЗХЯ/127 гэрээ; 1.4. "Ньюсоник" ХХК-тай байгуулсан ЭЗХЯ/139 бараа нийлүүлэх гэрээ; 1.5. "НЬЮС АЖЕНСИ" ХХК-тай байгуулах "Ажил гүйцэтгэх" ЭЗХЯ/87 гэрээ; 1.6. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудтай байгуулах "Хөлсөөр ажиллах" ЭЗХЯ/135 гэрээ; 1.7. ЭЗХЯ/122, ЭЗХЯ/130, ЭЗХЯ/138 дугаар бүхий тэтгэлэгт хөтөлбөрийн суралцагч болон албан байгууллага хоорондын гэрээ; 1.8. ЭЗХЯ/146, ЭЗХЯ/147, ЭЗХЯ/148, ЭЗХЯ/149 дугаар бүхий үйлчилгээ үзүүлэх, түрээсийн гэрээнүүд; 1.9. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх ЭЗХЯ/160 гэрээний төслийг боловсруулж, талуудаар батлуулсан; 2. Дараах зураг төсөл, төсөв ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний үндсэн гэрээнүүдийг боловсруулан талуудаар батлуулж, шаардлагатай тохиолдолд тухай бүр нэмэлт гэрээнүүдийн төслийг боловсруулан мөн талуудаар батлуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2.1. Сумын нэгдсэн дулаан хангамжийн эх үүсвэрийн барилгыг, шинээр барих, өргөтгөл шинэчлэлийн ажлын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зураг төсөл - гүйцэтгэгч Дөрвөнгүн ХХК 2.2. Сумын нэгдсэн дулаан, цэвэр усны хангамж, төвлөрсөн бохир усны шугамын ажлын зураг төсөл - гүйцэтгэгч Монкузбасс ХХК 2.3. Бага газрын чулууны аялал жуулчлалын бүсийн зураг төсөл - гүйцэтгэгч Стийл проект ХХК 2.4. Өмнөговь аймгийн Шүүхийн барилгын зураг, төсөв - гүйцэтгэгч ММ архитектур ХХК 2.5. Алтанбулаг чөлөөт бүс доторх замын зураг төсөл - гүйцэтгэгч Гео урбан консалтинг ХХК 2.6. Сургуулийн барилгын жишиг нэг маягийн зураг төсөв - гүйцэтгэгч Төгс гранд констракшн ХХК | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өөрийн хариуцсан ажлын хүрээнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байх | Сургалтад хамрагдсан байх | - | Сургалтад хамрагдсан байх | 1. Бүгд найрамдах Солонгос Улсын Хүний нөөцийн удирдлагын сайдын "Ким Сын Хо"-ийн "Улсын хөгжлийг түүчээлэх чадварлаг төрийн албан хаагч" лекцэд /2024.03.22/ хамрагдсан. 2. Монгол Улсын Засгийн газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОБЕГ-аас зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургалтад/2024.03.28/ хамрагдсан. 3. Удирдлагын академийн "Microsoft 365 программын хэрэглээ" сэдэвт сургалтад амжилттай хамрагдаж, албан ёсны гэрчилгээтэй болсон. 4. Удирдлагын академийн "Төсвийн хөрөнгө оруулалт" цахим сургалтад сууж, төсвийн хөрөнгө оруулалтын тухай ойлголт, бүрэлдэхүүн хэсэг, хөрөнгө оруулалтын үе шат, төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах арга зам талаар тодорхой хүрээний мэдлэг эзэмшсэн. 5. Удирдлагын академийн "Монгол Улсын төсөв" цахим сургалтад сууж, төсвийн эрх зүйн орчин, улсын төсвийн бүтэц, цагалбар, улсын болон орон нутгийн төсвийн харилцаа, төсвийн ил тод байдалд оруулах иргэдийн оролцоо зэрэг ойлголтын талаар суралцсан. 6. Удирдлагын академийн "Тоон гарын үсэг" цахим сургалтад сууж, тоон гарын үсэг гэж юу болох тухай, тоон гарын үсгийн давуу талууд, тоон гарын үсэг хэрхэн ашиглах талаарх мэдээллийг олж авсан. 7. Удирдлагын академийн Төрийн албанд шинээр томилогдсон | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамрагдан, суралцаж байна. | | |
| 2 | Хариуцсан ажлын хүрээнд хэлэлцүүлэг, семинар, уулзалт, мэдээллийн цагт оролцсон байх | Сургалтад хамрагдсан байх | - | Сургалтад хамрагдсан байх | 1. Эдийн засаг, хөгжлийн яам нь Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй PIP-MIS /Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн цахим систем/-ийн танилцуулга, хэлэлцүүлэгт оролцсон. 2. Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулсан "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл"-ийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээнд оролцсон. 3. Эдийн засаг, хөгжлийн яамны ХОБГ-аас 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн журам, аргачлалын талаарх семинарт ТЗУГ-аас төлөөлөн оролцсон. 4. Эдийн засаг ба хууль тогтоомжийн уламжлал, шинэчлэл, тулгамдсан асуудал эрдэм шинжилгээний хэлэлцүүлэгт оролцсон. 5. Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлэх сургалт болох анхан шатны Монгол бичгийн сургалтад хамрагдаж дуусгасан бөгөөд Монгол бичгийн анхан шатны шалгалтад тэнцсэн. 6. Эдийн засаг, хөгжлийн яамны Ёс зүйн дэд хороо болон сэтгэл судлаач Э.Номунгэрэл хамтран зохион байгуулсан “Ажлын байрны сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт сургалтад хамрагдсан. | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3 | Яамны мэдээллийн цагт тогтмол оролцож, суралцах | Мэдээллийн цагт хамрагдсан байх | - | Мэдээллийн цагт хамрагдсан байх | 1. 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулагдсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-ийн талаар танилцуулсан мэдээллийн цагт оролцож, төр, хувийн хэвшлийн | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р | 100% |

286

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | түншлэлийн талаарх нарийн мэдээллийг олж авсан. 2. 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан "Дипломат ёслол"-ийн талаар илтгэл танилцуулсан "мэдээллийн цагт" оролцож, дипломат ёсны талаар өргөн хүрээний мэдлэгийг олж авсан. 3. 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн мэдээллийн цагаар Зайнаас ажиллах журмын танилцуулга болон зайнаас ажилласан тохиолдолд албан хаагчдын цахим системийн бүртгэлийг хэрхэн хийх талаар нийт албан хаагчдад танилцуулсан. 4. 2024 оны 09 сарын 20-ны өдөр зохион байгуулсан "Захиргааны хэм хэмжээний акт, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал" сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. 5. 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Усны газрын дарга З.Батбаярын илтгэсэн "Ус, усны нөөц ирээдүй", Эрчим хүчний зохицуулах хорооны мэргэжилтэн Д.Наранцэцэгийн илтгэсэн "Эрчим хүч хэмнэх боломжууд" сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. | сар, 11-р сар, 12-р сар | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалт, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Бадамдорж Баасансүрэн /.........Баасансүрэн........................./ Огноо: .........................